



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 263

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 59,900,000 (тавин есөн сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 4,159,722.20 (дөрвөн сая нэг зуун тавин есөн мянга долоон зуун хорин хоёр төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Улсын ерөнхий прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2."Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран, Улсын Ерөнхий Прокурорын газрын улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0001991

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 6 дугаар сарын 12 ны өдрийн
 263 дугаар тогтоолын хаваралт



**"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРААС УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАРТ
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ниссан Тиана, 08-87 УБҮ, IN4AL3AP4GC188609, Суудлын автомашин	2016/2017	16700	59,900,000.00	4,159,722.20	55,740,277.80
НИЙТ ДҮН				59,900,000.00	4,159,722.20	55,740,277.80
				(тавин есөн сая есөн зуун мянган)	(дөрвөн сая нэг зуун тавин есөн мянга долоон зуун хорин хоёр төгрөг хорин мөнгө)	(тавин таван сая долоон зуун дөчин мянга хоёр зуун далан долоон төгрөг наян мөнгө)